



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/475

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт ертгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бүжигчдийн хувцас, хэрэглэл материалын зардал 8,760,000 (найман сая долоон зуун жаран мянга) төгрөгийг хавсралтаар баталж, хууль, дүрэм журмын дагуу гэрээ байгуулах эрхийг Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг)-д олгосугай.

2.Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3.Дээрх хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4.Гэрээний биелэлтийн дагуу хувцас, хэрэглэл материалыг бүртгэл хөтөлж, тайлагнахыг Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010593

07 дүгээр сарын 07-ны өдрийн 4/475 дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт



Хувцас зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.	2	3	4	5
1.	Эрэгтэй бүжгийн хувцас /иж бүрдэл/ ➢ Уналттай шарваар ➢ Даавуун дан цамц ➢ Торгон Хантааз ➢ Даавуун бүсэлхийтэй дээл	12ш	250,000	3,000,000
2.	Эмэгтэй бүжгийн хувцас /иж бүрдэл/ ➢ Уналттай наран хормойтой ➢ Торгон эмжээртэй ➢ Даавуун дээл	12ш	230,000	2,760,000
3.	Хөгжимчдийн хувцас /иж бүрдэл эрэгтэй, эмэгтэй/ ➢ Хүннү захтай торгон дээл	10ш	300,000	3,000,000
Нийт дүн			8,760,000	